



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 7/666.

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймаг, орон нутгийн онцлогтой стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Гансүх

-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Б.Оюунтуяа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга

С.Энхзаяа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

М.Үүрийнбаяр

-Эрүүл мэндийн газрын дарга

Т.Раднаабүд

-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
газрын дарга

П.Мөнхжаргал

-Байгаль орчны газрын дарга

О.Бадраа

-Боловсролын газрын дарга

Д.Сумаадагва

-Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын Хөвсгөл аймаг
дахь хэлтсийн дарга

Я.Эрхэмбаяр

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичгийн дарга:

М.Даваадулам

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах
мэргэжилтэн


2. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх чиглэлээр салбарын хэмжээнд шаардлагатай

6712012043

хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг, орон нутгийн онцлогтой стратеги төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний төслийг Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлэхийг ажлын хэсэг (Ц.Гансүх)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР